

ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ

Б.БЯМБАДОРЖ

2024 оны 01 сарын 25-ны өдөр

**Нөөцөд бэлтгэх ногоон толгойтой ногоон тэжээлийн техникийн тодорхойлолт**

1. Барааны тодорхойлолт :

-Нийлүүлэх толгойтой ногоон тэжээл нь 2023 оны намрын ургацаас бэлтгэсэн ногоон, цайвар ногоон өнгөтэй, хөлдөж хөгцрөөгүй, тоос багатай элдэв үнэргүй

- Өвс цайж хөхрөөгүй, харлаж борлоогүй, чийггүй байх ёстой.

- Харлаж хөгцөрсөн, ялзарч муудсан толгойтой ногоон тэжээлийг сумын нөөцөд нийлүүлэхийг хориглоно.

2.Баглаа боодол : Зориулалтын баглаа боодолтой байх. Ногоон тэжээлийн боодол задраагүй байх/ шаардлага хангаагүй болон боодол задарсан толгойтой ногоон тэжээлийг хүлээн авахгүй.

3. Бараа хүргэх газар: Тухайн ачилт, буулгалт хүргэлтийн зардлыг тухайн Аж ахуйн нэгж хариуцах. Сумын аюулгүйн нөөцөд 25.000.000 төгрөг, Жаргалант багт 5,000,000 төгрөгний толгойтой ногоон тэжээл хүргэнэ.

Сумын нөөцөд нийлүүлэх ногоон тэжээлийг зориулалтын мяндсан утсаар боосон байх.

№	Үзүүлэлт	Хэмжээ, чанарын тодорхойлолт
1	Нэг боодол өвсний хэмжээ см,-ээр	50x30x80
2	Нэг боодол өвсний жин кг-аас багагүй	25
3	Нэг боодол өвсний нягтрал кг,/м3-аас багагүй	120-150 кг/м3 байхаар нягт боогдсон байна.
4	Элс шорооны хольц %-иас ихгүй	0,5%-иас ихгүй
5	Өнгө	ногоон, цайвар ногоон өнгөтэй
6	Үнэр	Өвсний өвөрмөц анхилуун үнэртэй
7	Уян чанар	Уян зөөлөн
8	Сөөг ургамал %-иас ихгүй	10
9	Хорт ба хөнөөлт ургамал, %-иас ихгүй	0,5
10	Хагд өвсний хэмжээ %-иас ихгүй	5

## Нөөцөд бэлтгэх хуурай хивэгний техникийн тодорхойлолт

### 1. Барааны тодорхойлолт:

-Нийлүүлэх хуурай хивэг нь Үйлдвэрийн нэр, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн он сар өдөр, орц, найрлага, чанарын үзүүлэлтүүдийг бүрэн илэрхийлсэн байна

- Өөрийн өвөрмөц үнэр, гадны ямар нэгэн үнэр байж болохгүй

- Тэжээлийн найрлагыг лабораторид тодорхойлуулж, чанарын үзүүлэлтүүдийг тодорхой болгосон болно.

2.Баглаа боодол: Хивгийг 25кг хүртэл жинтэй савлах ба уутны амыг захаас нь 3-аас 5 см зай гаргаж оёсон байна. Шуудайны боодол задраагүй байх/ шаардлага хангаагүй болон задарсан шуудайтай хивгийг хүлээн авахгүй.

3.Бараа хүргэх газар: Тухайн ачилт, буулгалт хүргэлтийн зардлыг тухайн Аж ахуйн нэгж хариуцах. Сумын аюулгүйн нөөцөд 25.000.000 төгрөг, Жаргалант багт 5,000,000 төгрөгний хуурай хивэг хүргэх.

Стандартын дагуу өрж байрлуулна.

4.Ачилт буулгалт, хураалтын зардлыг тухайн нийлүүлэгч ААН хариуцна.

№	Үзүүлэлт	Хэмжээ, чанарын тодорхойлолт
1	Өнгө	Жигд боровтортой туяатай, улаан шаргал өнгөтэй
2	Үнэр	Өөрийн өвөрмөц үнэр, гадны ямар нэгэн үнэр байж болохгүй
3	Механик хольц а/1 кг хивгэнд 0,5-аас 2мм хүртэлх жижиг хэсгүүд МГ-аар б/2мм-ээс дээш хэмжээтэй хурц үзүүртэй ирмэгтэй металл хэсэг	1,5-аас ихгүй Байж болохгүй
4	Хорт хольц/ харуу, харга хамтдаа буюу дангаар %-иас ихгүй	0,05
5	Агуулахын хортон	Байхгүй
6	Пестицид Мг/кг (ихгүй )	0.1
7	Чийг, %-иас ихгүй	15,0
8	Нийт протейн, %-иас багагүй	14,0
9	Тос %-иас ихгүй	2,8
10	Нийт эслэг, %-иас ихгүй	8,0

11	Үнс, %-иас ихгүй	6,0
12	Савлагаа	Хивгийг 50кг хүртэл жинтэй савлах ба уутны амыг захаас нь 3-аас 5 см зай гаргаж оёсон байна.
13	Хаяг	Үйлдвэрийн нэр, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн он сар өдөр, орц, найрлага, чанарын үзүүлэлтүүдийг бүрэн илэрхийлсэн байна.
14	Тоо, ширхэг /уут/	Уут хивэгний жин 25кг

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН  
БЭЛЧЭЭР ГАЗАР ТАРИАЛАН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН *Д. Нарантуяа* Д.НАРАНТУЯА